



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН  
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ  
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд зөвлөл байгуулах тухай хурлын тэмдэглэл

Хуралд: төвийн захирал А.Буяннэмэх, ГХБАБМХ-ийн дарга Ц.Оюунбат, ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргил, Ж.Алимаа, М.Оюун-Ундрэм, мэргэжилтэн О.Оюунболд, Т.Мейрамбек, Д.Дарьсүрэн, Г.Байгалмаа, Л.Хишигжаргал, М.Үүрийнтуяа, үйлчлэгч Д.Дуламханд нар оролцов. Нийт 18 ажилтнаас 4 ажилтан ээлжийн амралттай, 2 ажилтан чөлөөтэй байсан тул хуралд цахимаар оролцов. Ирц 100 хувь.

**Хэлэлцсэн асуудал:** төвийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог байгуулах тухай

**Захирал А.Буяннэмэх :** Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан төвийнхөө хэмжээнд ёс зүйн дэд хороог байгуулах чиглэл Зам, тээврийн яамнаас ирсэнтэй холбогдуулан өнөөдрийн хурлыг хийж байна. Тэгэхээр ёс зүйн дэд хорооны гишүүдэд хэн хэнийг сонгох талаараа хэлэлцье. Би хувьдаа ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргилыг, хууль М.Үүрийнтуяаг, Хүний нөөц М.Оюун-Ундрэм нарыг ажиллуулах саналтай байна. Та бүхэн өөр өөрийн саналаа өгөөрэй.

**Хэлтсийн дарга Ц.Оюунбат:** ахлах мэргэжилтэн Бат-Оргил болон хуульч Үүрийнтуяа нарыг сонгоход татгалзах зүйлгүй. Харин Оюун-Ундрэм хувьд хүний нөөц нь өөрөө ёс зүйн хороондоо байх нь жаахан учир дутагдалтай, захиргааг ч, ажилтнаа ч төлөөлж явдаг хүн шийдвэр гаргаад явахад хүндрэлтэй байж мэднэ. Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Э.Осоржамааг оруулбал яаж байна.

**Ахлах мэргэжилтэн М.Оюун-Ундрэм:** Э.Осоржамаа ах бас ёс зүйн дэд хороонд ажиллахад тохиромжгүй болоод байна ажил мэргэжлийн хувьд. Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд уг хорооны үйл ажиллагаанд байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргаж явах заалт тусгагдсан байгаа болохоор ах ажиллаж болохгүй. Ажил үүрэг нь давхардаад байна. Өөр хүнийг л оруулах хэрэгтэй.

**Ахлах мэргэжилтэн Ж.Алимаа:** тэгвэл 2 гишүүн нь тодорхой байгаа юм чинь ахлах мэргэжилтэн Д.Өлзийсайханыг 3 -дагч гишүүнээр сонгож болох уу? Миний хувьд энэ 3 хүн дээр татгалзах зүйлгүй.

**Мэргэжилтэн Д.Дарьсүрэн:** тийм ээ тийм. Өлзийсайхан байхад татгалзах зүйлгүй. Энэ 3 хүнийг дэмжиж байна.

**Захирал А.Буяннэмэх:** за бусад хүмүүст санал оруулах хүн байна уу? Бүгд энэ 3 хүнийг дэмжиж байна уу, эсвэл аль нэгийг нь солигоор байгаа бол санаагаа одоо хэлээрэй. Ер нь бол энэ хүмүүс та хэдийн ёс зүйн асуудлаар гаргасан зөрчил дутагдлыг шүүнэ шүү дээ, бас аливаа эрсдэлээс хамгаална. Зоригтой саналаа хэлцгээ.

**Мэргэжилтэн О.Оюунболд:** миний хувьд энэ 3 хүнээ бүрэн дэмжиж байна. Бат-Оргил ах бол ажлын хэсэг, комисс, хороо зөвлөлд ажилласан арвин туршлагатай хүн, Хуульч Үүрийнтуяа хуулийн хүрээнд асуудлаа шийдээд явчихна, Өлзийсайхан эгч асуудлыг зөөлөн аргаар шийдчихдэг болохоор татгалзах зүйлгүй байна.

**Мэргэжилтэн Г.Байгалмаа:** миний хувьд татгалзах зүйлгүйэ

**Мэргэжилтэн Л.Хишигжаргал:** би бас зөвшөөрч байна.

**Захирал А.Буяннэмэх:** цахимаар орж байгаа ажилтнуудад хэлэх санал байна уу? Байхгүй бол ингээд шийдлээ.

**Мэргэжилтэн:** Г.Баттөр: миний хувьд ар гэрт гачигдал гарсан тул захиргааны чөлөөтэйгээр цахимаар хуралд орж байна. Татгалзах зүйлгүй.

*/ Цахимаар оролсон ажилтнууд бүгд зөвшөөрөв./*

**Хэлтсийн дарга Ц.Оюунбат:** дэд хорооны дарга, нарийн бчигээ бас сонгочих уу. Д.Бат Оргилыг дэд хорооны даргаар сонговол болж байна уу?

**Захирал А.Буяннэмэх:** за тэгвэл ёс зүйн дэд хороонд энэ 3 хүнийг ажиллуулахаар, даргаар нь Бат-Оргид ажиллахаар бүгд санал нэгтгэйгээр зөвшөрсөн гэж үзээд хурлаа дуусгая. М.Оюу-Ундрэм чи хурлын тэмдэглэлээ хөтлөөд, тушаалаа батлуулаарай. Ёс зүйн дэд хороо тушаалаа батлагдахаар ажилтны ёс зүйн дүрэм журмаа шинэчлээд явна биз. Хурал дууссаныг мэдэгдье.

**Нийт ажилтан:** дэмжиж байна аа. Татгалзах зүйлгүй.

**Ахлах мэргэжилтэн М.Оюун-Ундрэм:** За ойлголоо даргаа.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Төвийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Ёс зүйн дэд хорооны гишүүдээр ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргил, Д.Өлзийсайхан, хуульч М.Үүрийнтуяа нарыг ажилууллахаар нийт ажилтны 100 хувийн саналаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ИЙН ЗАХИРАЛ  
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

А.БУЯННЭМЭХ  
Д.БАТ-ОРГИЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн

М.Оюун-Ундрэм